

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны компани, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг тодорхойлох, тайланд тусгах тухай зааврыг хавсралтад дурдсанаар баталсугай.

2. Зааврыг үнэт цаасны компани, хөрөнгө оруулалтын сангуудад хүргэж зааварчлах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Д.Сэржамц/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

Монгол улсын Үнэт цаасны хорооны  
1996 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 61  
дүгээр тогтоолын хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОХ,  
ТАЙЛАНД ТУСГАХ ТУХАЙ ЗААВАР

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1. Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн болон хөрөнгө оруулалтын сангийн ажиллагаа эрхлэхээр Хорооноос тусгай зөвшөөрөл авсан, аж ахуйн биеэ даасан нэгжийн хэлбэрээр ажиллаж байгаа үнэт цаасны компани, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны үр дүнг тодорхойлохтой холбогдож үүссэн харилцааг зохицуулахад энэхүү зааврын зорилго оршино.

**ХОЁР. Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх**

2. Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлийг хоёр аргаар хөтөлнө.

1/ Тасралтгүй бүртгэх аргаар

2/ Хугацаагаар үечлэн бүртгэх аргаар

3. Үнэт цаасны төрөл тус бүрээр орлого, зарлагын хөдөлгөөн гарсан тухай бүрт нь дэлгэрэнгүй бүртгэлд тусгаж бүртгэхийг тасралтгүй бүртгэх арга гэнэ. Үнэт цаасны орлого зарлагын гүйлгээ гарсан өдрийн эхний үлдэгдэл дээр орлогын гүйлгээг нэмж, зарлагын гүйлгээг хасч өдөр тутам эцсийн үлдэгдлийг тодорхойлох замаар бүртгэнэ.

4. Нийт орлого, нийт зарлагын дүнг сар, улирлаар тодорхойлж сарын /улирлын/ эхний үлдэгдэл дээр тухайн сарын /улирлын/ нийт орлогыг нэмж, гарсан дүнгээс нийт зарлагыг хасаж, сарын /улирлын/ эцсийн үлдэгдлийг тодорхойлох замаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөхийг хугацаагаар үечлэн бүртгэх арга гэнэ. Хугацаагаар үечлэн бүртгэх аргыг хэрэглэхдээ үнэт цаасны орлого, зарлагын хөдөлгөөнийг тухайн өдөрт нь дэлгэрэнгүй бүртгэлд тусгана.

5. Тасралтгүй бүртгэх аргаар үнэт цаасны орлого зарлагын хөдөлгөөнийг бүртгэж байгаа тохиолдолд дундаж үнийг орлого зарлагын гүйлгээ хийсэн тухай бүрт тодорхойлно.

Хугацаагаар үечлэн бүртгэх аргаар бүртгэл хөтөлж байгаа бол сарын /улирлын/ эцэст тухайн хугацааны дундаж өртгийг тодорхойлно.

6. Үнэт цаасны хөдөлгөөний дэлгэрэнгүй бүртгэлийг Маягт №А11-1-ээр хөтөлнө. /1 дүгээр хавсралт/

Уг маягтад үнэт цаасны нэр төрөл, нэрлэсэн үнэ, хүү болон бусад нөхцлийг тусгана. Хэрэв хүүтэй үнэт цаас, тухайлбал Засгийн газрын өрийн бичиг, компаниудын зээллэг /бонд/ зэрэг үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж байгаа бол хүүний хэмжээ, хугацаа, нөхцөл, энгийн болон давуу эрхтэй хувьцаанд олгохоор зарласан ногдол ашиг зэрэг үзүүлэлтийг тодорхой заана.

7. Үнэт цаасны орлого зарлагын гүйлгээ нэг бүрээр уг маягтыг хөтлөх бөгөөд үнэт цаасны орлогыг худалдаж авсан үнээр, зарлагыг худалдсан үнээр харуулна.

8. Дэлгэрэнгүй бүртгэлийг тасралтгүй бүртгэх аргаар хөтөлж байгаа бол гүйлгээ бүрийн дараа үлдэгдлийг тодорхойлно. Түрүүлж ирснийг эхэлж зарлагдах /ТИЭЗ/ сүүлд ирснийг эхэлж зарлагдах /СИЭЗ/ аргын аль нэгийг хэрэглэж байгаа бол тухайн худалдан авсан үнээр үлдэгдлийг үнэлнэ.

9. Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлийг хугацаагаар үечлэн бүртгэх аргаар хөтөлж байгаа бол тухайн сарын эхний үлдэгдэл дээр орлогын дүнг нэмж, зарлагын дүнг хасч эцсийн

үлдэгдлийг тодорхойлно. Ийнхүү тодорхойлсон эцсийн үлдэгдлийг өртгөөр нь /ТИЭЗ, СИЭЗ аргын аль нэгийг хэрэглэж байгаа бол худалдаж авсан үнээр нь, дундаж өртгийн арга хэрэглэж байгаа бол дундаж үнээр нь/ үржүүлж эцсийн үлдэгдлийн үнийн дүнг тооцно.

Сарын сүүлчийн өдрийн хаалтын ханшаар тухайн үнэт цаасны зах зээлийн үнийг тодорхойлж дэлгэрэнгүй бүртгэлд тусгана. Энэ нь өртөг ба зах зээлийн үнийн аль аль багаар үнэт цаасыг балансад тусгах үндэслэл болно.

### **ГУРАВ. Борлуулалтын орлого тодорхойлох**

10. Тайлангийн хугацаанд худалдсан үнэт цаас, үзүүлсэн үйлчилгээний орлогыг компанийн борлуулалтын орлогод тооцно.

11. Борлуулалтын орлогыг бэлэн мөнгөөр эсхүл дараа тооцоогоор үүссэн орлого гэж ангилна.

Үнэт цаасны тухай Монгол улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 10 дахь заалтын дагуу үнэт цаасыг заавал бэлэн мөнгөөр худалдах бөгөөд дараа тооцоогоор /зээлээр/ худалдахыг хориглоно. Харин зөвлөгөө өгөх зэрэг бусад үйлчилгээний орлогыг дараа тооцоогоор авч болно.

12. Борлуулалтын нийт орлогоос буцаасан борлуулалтын орлогыг хасч борлуулалтын цэвэр орлогыг тодорхойлно. Буцаасан борлуулалтын орлого гэдэгт хэлцэл буцсанаас буцаасан үнэт цаасны борлуулалтын орлого, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс буцааж төлсөн үйлчилгээний төлбөр, шимтгэл зэрэг хамаарна.

### **ДӨРӨВ. Борлуулалтын өртөг тодорхойлох**

13. Үнэт цаасны эхний үлдэгдэл дээр тухайн тайлангийн хугацаанд худалдаж авсан үнэт цаасны цэвэр өртгийг нэмж, түүнээс үнэт цаасны эцсийн үлдэгдлийг хасч үнэт цаасны борлуулалтын өртгийг тодорхойлно.

14. Нийт худалдан авсан үнэт цаасны үнийн дүнгээс буцаасан үнэт цаасны /хэлцэл буцсан/ үнийн дүнг хасч тайлангийн хугацаанд худалдаж авсан үнэт цаасны цэвэр өртгийг тодорхойлно.

15. Үнэт цаасны үлдэгдэл болон борлуулалтын өртгийг тооцоход, түрүүлж ирснийг эхэлж зарлагдах /ТИЭЗ/; сүүлд ирснийг эхэлж зарлагдах /СИЭЗ/; жигнэсэн дундаж өртгийн аргын аль нэгийг хэрэглэнэ. Үнэт цаасны үлдэгдэл ба борлуулалтын өртгийн тооцоог Маягт №11-2-оор хийнэ. / 2 дугаар хавсралт/

#### **15.1. Түрүүлж ирснийг эхэлж зарлагдах арга**

Үнэт цаасны борлуулалтын өртгийг тооцох ТИЭЗ аргыг хэрэглэх үед түрүүлж худалдан авч орлого болгосон үнэт цаасыг эхэлж зарлагадана.

Энэ аргыг жишээгээр үзүүлбэл:

“А” компанийн энгийн хувьцаа:

1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл: 800 ш. нэг бүр нь 200 төгрөгийн үнэтэй.

1 дүгээр сарын 4: Нэг бүрийг нь 220 төгрөгөөр 300 ш. хувьцаа худалдан авсан.

1 дүгээр сарын 15: Нэг бүрийг нь 230 төгрөгөөр 400 ш. хувьцаа худалдан авсан.

1 дүгээр сарын 20: Нэг бүрийг нь 250 төгрөгөөр 600 ш. хувьцаа худалдсан.

1 дүгээр сарын 25: Нэг бүрийг нь 240 төгрөгөөр 300 ш. хувьцаа худалдан авсан.

1 дүгээр сарын 28: Нэг бүрийг нь 250 төгрөгөөр 800 ш. хувьцаа худалдсан.

Энд өгөгдсөн нөхцлийг үндэслэн тухайн үнэт цаасны хөдөлгөөний дэлгэрэнгүй бүртгэлийг Маягт №11-1-ээр хөтлөх аргачлалыг 1 дүгээр хүснэгтээр мөн ТИЭЗ аргаар үнэт цаасны үлдэгдэл болон борлуулалтын өртгийн тооцоог Маягт №А11-2-оор хийх аргачлалыг 2 дугаар хүснэгтээр харуулав.

Энэ аргаар тооцоо хийхэд тухайн хувьцааны борлуулалтын нийт ашиг дараах байдалтай болно.

- Борлуулалтын орлого  
 $600+800=1400$  ширхэг  $1400 \times 250\text{төг}=350000$  төгрөг
- Үлдэгдэл үнэт цаасны өртөг  
 $/100 \times 230\text{төг}/ + /300 \times 240 \text{төг}/ = 23000+72000 = 95000$
- Нийт үнэт цаасны үнийн дүн  
 $160000 \text{төг} + 230000 \text{төг} = 390000$  төгрөг
- Борлуулалтын өртөг  
 $390000 \text{төг} - 95000 \text{төг} = 295000$
- Борлуулалтын нийт ашиг  $350000 \text{төг} - 295000 \text{төг} = 55000 \text{төг}$

### 15.2. Сүүлд ирснийг эхэлж зарлагдах арга

Үнэт цаасны үлдэгдэл болон борлуулалтын өртгийг тооцох СИЭЗ аргыг хэрэглэх үед сүүлд худалдан авч орлого болгосон үнэт цаасыг эхэлж зарлагадана.

Дээр өгөгдсөн нөхцөлийг үндэслэн СИЭЗ аргаар үнэт цаасны үлдэгдэл болон борлуулалтын өртгийн тооцоог Маягт №11-2-оор хийх аргачлалыг 3 дугаар хүснэгтээр харуулав.

Энэ аргаар тооцоо хийхэд тухайн хувьцааны борлуулалтын нийт ашиг дараах байдалтай болно.

- Борлуулалтын орлого нь:  
 $1400 \times 250\text{төг}=350000$  төгрөг
- Үлдэгдэл үнэт цаасны өртөг  
 $400 \times 200\text{төг}=80000$  төгрөг
- Нийт үнэт цаасны өртөг дээрхтэй адил  $390000$
- Борлуулалтын өртөг нь:  $390000-80000 = 310000$  төгрөг
- Борлуулалтын нийт ашиг нь:  $350000 \text{төг} - 310000 \text{төг} = 40000$  төгрөг

### 15.3 Жигнэсэн дундаж өртгийн арга

Үнэт цаасны жигнэсэн дундаж үнийг үнэт цаасны төрөл тус бүрээр гаргана. Үнэт цаасны нийт үнийн дүнг тэдгээрийн тоо ширхэгт хувааж нэгжийн жигнэсэн дундаж үнийг тодорхойлно /Хавсралт 2/. Үнэт цаасны дундаж үнийг 1 төгрөг хүртэл нарийвчлалтай тооцно. Нэгжийн жигнэсэн дундаж үнээр үнэт цаасны үлдэгдлийг үржүүлж үлдэгдэл үнэт цаасны үнийн дүнг тодорхойлно. Үнэт цаасны нийт үнийн дүнгээс үлдэгдэл үнэт цаасны үнийн дүнг хасч үнэт цаасны борлуулалтын өртгийг тодорхойлно.

16. Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлийг тасралтгүй бүртгэх аргаар хөтөлж байгаа тохиолдолд үнэт цаасыг шинээр орлого болгосон /худалдан авсан/ тухай бүрт жигнэсэн дундаж үнийг шинээр тодорхойлно. Зарлага болгосон /худалдаж борлуулсан/ тухай бүрт тухайн өдрийн дундаж ханшаар тооцож үлдэгдэл үнэт цаасны үнийн дүнг тодорхойлох бөгөөд нийт үнийн дүнгээс үлдэгдлийн үнийн дүнг хасч борлуулсан үнэт цаасны өртгийг тодорхойлно.

17. Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлийг хугацаагаар үечлэн бүртгэх аргаар хөтөлж байгаа тохиолдолд тухайн тайлангийн үеийн /сар, улирлын/ эхний үлдэгдэл дээр тайлангийн

үеийн нийт орлогыг нэмж тодорхойлсон үнийн дүнг тоо ширхэгт нь харьцуулж тайлангийн үеийн дундаж үнийг тодорхойлно. Энэ дундаж үнээр тайлангийн үеийн эцсийн үлдэгдлийг үржүүлж үлдэгдэл үнэт цаасны өртгийг тодорхойлно. Үнэт цаасны нийт дүнгээс үлдэгдлийн үнийн дүнг хасч борлуулсан үнэт цаасны өртгийг тодорхойлно.

Дээр өгөгдсөн нөхцлийг үндэслэн Маягт №А11-2-оор жигнэгдсэн дундаж өртгийн аргаар үнэт цаасны үлдэгдэл болон борлуулалтын өртөг тодорхойлох аргачлалыг 4 ба 5 дугаар хүснэгтээр харуулав.

Тасралтгүй бүртгэх аргаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж байгаа тохиолдолд дундаж өртгийн аргаар үнэт цаасны үлдэгдэл болон борлуулалтын өртгийг тооцоход /4 дүгээр хавсралт/ борлуулалтын нийт ашиг нь дараах байдалтай болно.

-Борлуулалтын орлого нь:

$$1400 \times 250 \text{ төг} = 350000 \text{ төгрөг}$$

-Борлуулалтын өртөг нь:

$$/600 \times 212 \text{ төг}/ + /800 \times 219 \text{ төг}/ = 127200 \text{ төг} + 175200 \text{ төг} = 302400 \text{ төгрөг}$$

-Борлуулалтын нийт ашиг нь:

$$350000 \text{ төг} - 302400 \text{ төг} = 47600 \text{ төгрөг}$$

19. Хугацаагаар үечлэн бүртгэх аргаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж байгаа тохиолдолд жигнэгдсэн дундаж өртгийн аргаар үнэт цаасны үлдэгдэл болон борлуулалтын өртгийг тооцоход /5 дугаар хүснэгт/ борлуулалтын нийт ашиг нь дараах байдалтай болно.

Нийт хувьцааны тоо нь:  $800 + 1000 = 1800$  ширхэг

-Нийт үнэт цаасны үнийн дүн:

$$160000 \text{ төг} + 230000 \text{ төг} = 390000 \text{ төгрөг}$$

$$\text{Дундаж өртөг нь: } 390000 \text{ төг} : 1800 = 217 \text{ төгрөг}$$

Энэ дундаж өртгөөр үнэт цаасны үлдэгдлийг үржүүлж үлдэгдлийн өртгийг тодорхойлбол:

$$400 \times 217 \text{ төг} = 86800 \text{ төгрөг}$$

Нийт өртгөөс үлдэгдлийн өртгийг хасч борлуулалтын өртгийг тодорхойлбол:

$$390000 \text{ төг} - 86800 \text{ төг} = 303200 \text{ төгрөг}$$

-Борлуулалтын орлого нь:

$$1400 \times 250 \text{ төг} = 350000 \text{ төгрөг}$$

-Борлуулалтын өртөг нь: 303200 төгрөг

-Борлуулалтын нийт ашиг нь:

$$350000 \text{ төг} - 303200 \text{ төг} = 46800 \text{ төгрөг}$$

### **ТАВ. Үнэт цаасны үлдэгдлийг балансад тусгах**

20. Санхүүгийн бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмын дагуу үнэт цаасыг өртөг ба зах зээлийн үнийн аль багаар нь үнэлж санхүүгийн тайланд тусгана.

21. Үнэт цаасны өртөг нь худалдан авсан үнэ байна.

22. Өртөг ба зах зээлийн үнийн аль багаар нь үнэлэх аргыг 3 ангилна.

1/ Нэр төрөл тус бүрээр үнэлэх арга

2/ Гол бүлгээр үнэлэх арга

3/ Нийт дүнгээр үнэлэх арга

Эдгээр аргыг хэрэглэх жишээ авч үзвэл:

“Санар” үнэт цаасны компанийн 1996 оны үйл ажиллагааны үзүүлэлтүүд дараах байдалтай байв.

- 1996 оны борлуулалтын орлого 3600000
- 1996 оны эхний үнэт цаасны багцийн үлдэгдэл 256000
- 1996 онд худалдан авсан нийт үнэт цаасны өртөг /худалдан авсан үнэ/ 2900800
- 1996 оны эцсийн үнэт цаасны багцийн үлдэгдлийг 6 дугаар хүснэгтээр харуулав.

Энэ хүснэгтээр үнэт цаасны үлдэгдлийг өртөг ба зах зээлийн үнийн аль багаар нь үнэлэх 3 аргыг хэрэглэх онцлогыг үзүүлбэл:

6 дугаар хүснэгт

“Сансар” үнэт цаасны ХХК-ийн эзэмшиж байгаа үнэт цаасны үнэлгээ 1996 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

| Үнэт цаасны нэр төрөл             | Өртөг  | Зах зээлийн үнэ /1996.12.31-ний хаалтын ханшаар/ | Өртөг ба зах зээлийн ханшийн бага нь |             |              |
|-----------------------------------|--------|--|--------------------------------------|-------------|--------------|
|                                   |        |  | Нэр төрөл тус бүрээр                 | Гол бүлгээр | Нийт дүнгээр |
| 1.”А” ХК-ийн энгийн хувьцаа       | 86800  | 104000   | 86800                                |             |              |
| 2.”Арвижих” ХК-ийн энгийн хувьцаа | 100000 | 90000  | 90000                                |             |              |
| 3.”Эрмэл” ХК-ийн энгийн хувьцаа   | 50000  | 40000  | 40000                                |             |              |
| Дүн                               | 236800 | 234000   | 216800                               | 234000      |              |
| 1.”Хан-Уул” ХК бонд               | 90000  | 48000  | 48000                                |             |              |
| 2.”Хайрхан” ХК бонд               | 95000  | 92000  | 92000                                |             |              |
| Дүн                               | 185000 | 140000   | 140000                               | 140000      |              |
| Нийт дүн                          | 421800 | 374000   | 356800                               | 374000      | 374000       |

Тус компанийн эзэмшиж байгаа үнэт цаасны багцийг нэр төрөл тус бүрээр үнэлэх аргаар тооцвол балансад 356800 төгрөгөөр, гол бүлгээр болон нийт дүнгээр үнэлэх аргаар тооцвол 374000 төгрөгөөр тус тус харуулна.

Зөвлөмж болгох нь:

Нэр төрөл тус бүрээр үнэлдэг аргыг хэрэглэх нь илүү тохиромжтой.

Дээрх тооцоогоор үнэт цаасны компанийн эзэмшиж байгаа үнэт цаасны багцыг өртгөөр нь тооцвол 421800 төгрөг байгаа бол тухайн оны эцсийн зах зээлийн үнээр /оны

сүүлчийн арилжааны хаалтын ханшаар тооцсон/ 356800 төгрөг болж байна. Ийм учраас 1996 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлангийн балансад үнэт цаасны багц нь 421800 төгрөгөөр биш 356800 төгрөгөөр тусгагдах ёстой. Дэлгэрэнгүй бүртгэлд 421800 төгрөгөөр үнэлэгдэж байгаа үнэт цаасыг балансад 356800 төгрөгөөр харуулах ёстой болж байгаа учраас энэ хоёрын зөрүү 65000 төгрөгийг бүртгэлд тусгана.

Уг зөрүүг бүртгэлд тусгахдаа 2 арга хэрэглэж болно.

- 1/ Шууд арга
- 2/ Шууд бус арга

Шууд арга хэрэглэхдээ үнэт цаасны үлдэгдлийг бага өртгөөр нь шууд авч борлуулалтын өртгийг тооцдог. Энэ тохиолдолд зөрүү нь борлуулалтын өртгийг шууд ихэсгэх /багасгах/ учраас зөрүү нь ашиг алдагдлын тайланд харагддаггүй.

Шууд бус аргаар бүртгэхдээ хөрөнгийн үнэлгээг тохируулах сөрөг данс нээнэ. Ингэснээр тухайн компанийн эзэмшиж буй үнэт цаасны багцын зах зээлийн үнэ өөрчлөгдсөнөөс олох ашиг /хүлээх алдагдал/-ыг тодорхойлж, тайланд тусгана. Борлуулалтын өртгийг тайланд бодитой тусгах боломж олгодог давуу талтай учраас энэ арга илүү тохиромжтой.

23. Энэ 2 аргыг хэрэглэж борлуулалтын өртөг, үнэт цаасны зах зээлийн үнийн өөрчлөлтөөс олох ашиг /хүлээх алдагдал/ зэргийг “Орлого, үр дүнгийн тайлан”-д хэрхэн тусгахыг жишээгээр авч харуулбал:

7 дугаар хүснэгт

### I. Шууд арга

|                                       |         |
|---------------------------------------|---------|
| 1. Борлуулалтын орлого                | 3600000 |
| 2. Үнэт цаасны багцын өртөг           |         |
| a. Эхний үлдэгдэл                     | 256000  |
| b. Худалдан авалт                     | 2900800 |
| ДҮН                                   | 3156800 |
| 3. Үнэт цаасны багцын эцсийн үлдэгдэл | 356800  |
| 4. Борлуулсан үнэт цаасны өртөг /2-3/ | 2800000 |
| 5. Нийт ашиг /1-4/                    | 800000  |

### II. Шууд бус арга

|                              |         |
|------------------------------|---------|
| 1. Борлуулалтын орлого       | 3600000 |
| 2. Үнэт цаасны багцын өртөг: |         |
| a. Эхний үлдэгдэл            | 256000  |
| б. Худалдан авалт            | 2900800 |
| ДҮН                          | 3156800 |
| 3. Эцсийн үлдэгдэл /өртгөөр/ | 421800  |

|  |         |
|--|---------|
| 4. Борлуулалтын өртөг                            | 2735000 |
| 5. Борлуулалтын нийт ашиг                        | 865000  |
| 6. Үнэт цаасны үнэ өөрчлөгдсөний ашиг /алдагдал/ | /65000/ |
| 7. Үйл ажиллагааны ашиг /5-6/                    | 800000  |

Хоёр аргын аль алинаар тооцоход ашиг адилхан 800000 төгрөг байгаа боловч шууд бус аргаар тооцоход үнэт цаасны борлуулалтаас 865000 төгрөгийн ашиг олсон боловч эзэмшиж байгаа үнэт цаасны багцын зах зээлийн үнэ буурснаас 65000 төгрөгийн алдагдал хүлээж нийт дүндээ 800000 төгрөгийн ашигтай ажилласныг тодорхой харуулж байна.

**Зургаа. Борлуулалтын болон бусад үйл ажиллагааны үр дүнг санхүүгийн тайланд тусгах журам**

24. Орлого, үр дүнгийн тайлан нь тайлангийн үеийн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнг харуулдаг санхүүгийн тайлангийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд орлого, зардал, ашиг гэсэн үндсэн элементээс бүрдэнэ.

25. Орлогод үнэт цаасны борлуулалт, эзэмшиж байгаа үнэт цаасны хүү, ногдол ашиг болон үзүүлсэн үйлчилгээний орлого орно. Орлогыг агуулгаар нь дараах байдлаар ангилна:

- Үндсэн үйл ажиллагааны
- Үйл ажиллагааны бус
- Санхүүгийн үйл ажиллагааны

25.1. Үндсэн үйл ажиллагааны орлого нь брокерын болон дилерийн үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ. Брокерын үйл ажиллагааны орлого нь үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилсны шимтгэл болно. Дилерийн үйл ажиллагааны орлого нь үнэт цаасны борлуулалтын орлого болон тухайн аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа үнэт цаасны хүү, ногдол ашиг болно.

Брокерын болон дилерийн үйл ажиллагааны орлого нь Орлого, үр дүнгийн тайланд тус тусдаа тусгагдана.

25.2. Үйл ажиллагааны бус орлого нь түрээсийн төлбөр, нийгэм хангамжийн зориулалттай нэгжүүдийн орлогоос бүрдэнэ.

25.3. Санхүүгийн үйл ажиллагааны ашиг орлого нь гадаад валютын ханшийн зөрүүгийн ашиг, үндсэн хөрөнгө, материал борлуулсны ашиг гэх мэт орлогоос бүрдэнэ.

26. Тодорхой хугацааны орлого, үр дүнгийн тайланг гаргахдаа тухайн тайлангийн хугацаанд хамрагдах орлого зарлагын ажил гүйлгээг аккруэл зарчмаар харуулна. Энэ зарчмаар үнэт цаасыг борлуулж, гадагш ажил, үйлчилгээ үзүүлсний дараа орлого нь мөнгөөр орсон, зардал нь төлөгдсөн болон тооцогдсон алин болохыг үл харгалзан тухайн тайлангийн үеийн орлого ба зардал болгон тооцно. Үндсэн ажиллагааны бус орлого нь үндсэн ажиллагааны орлогын үр дүнд хамаарахгүй.

27. Орлогын зүйл бүрт зардлын зүйл ангийг зохицуулан бүртгэх зарчмыг баримтална.

28. Ашиг нь үйл ажиллагааны үр дүнг хэмждэг үндсэн үзүүлэлт юм.

28.1 Орлого, үр дүнгийн тайланд ашиг алдагдлыг нийт ашиг /алдагдал/, үйл ажиллагааны ашиг /алдагдал/, татварын өмнөх ашиг /алдагдал/, цэвэр ашиг /алдагдал/ гэж үзүүлнэ.

28.2. Борлуулалтын орлогоос борлуулалтын өртгийг хасч, нийт ашгийг тодорхойлно.



28.3. Борлуулалтын өртгийг энэхүү журмын 4 дүгээр хэсэгт заасан аргуудын аль нэгийг баримтлан тодорхойлох бөгөөд чухам аль аргыг хэрэглэх талаар санхүүгийн жилийн эцэст Үнэт цаасны хороо болон холбогдох санхүү, татварын албатай тохиролцно.

28.4. Нийтээр хүлээн зөвшөөрсөн санхүүгийн бүртгэлийн зарчмын дагуу нэгэнт сонгон авсан аргыг тууштай баримтлах бөгөөд өөр арга хэрэглэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд учир шалтгааныг үндэслэлтэй тайлбарласан албан ёсны хүсэлтээ Үнэт цаасны хороо болон холбогдох санхүү, татварын албанд ирүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр санхүүгийн жилийн эхнээс хэрэглэнэ.

28.5. Хяналт тавих боломж, хэрэглэхэд тохиромжтой байдал зэргийг харгалзан үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөхөд хугацаагаар үечлэн бүртгэх аргыг /сараар/, борлуулалтын өртөг тооцоход дундаж өртгийн аргыг зөвлөмж болгож байна.

28.6. Энэ аргаас өөр арга сонгон хэрэглэх аж ахуйн нэгж нь үндэслэл, тодорхойлолтоо Хороонд ирүүлж зөвшөөрөл авна.

29. Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан зардлуудыг борлуулалтын ба ерөнхий удирдлагын гэж ангилан бүртгэх бөгөөд энэ тайланд үйл ажиллагааны зардал гэж нэгтгэн харуулна.

29.1. Үйл ажиллагааны зардалд цалин хөлс, шагнал, засвар үйлчилгээний зардал, ашиглалтын зардал, албан томилолт, ёслолын зардал, үнэт цаасны үнэ өөрчлөгдсөнөөс гарсан алдагдал, элэгдлийн болон бусад зардал орно.

29.2. Нийт ашгаас үйл ажиллагааны зардлыг хасаж үйл ажиллагааны ашиг /алдагдал/-ийг тодорхойлно.

29.3. Үйл ажиллагааны ашиг /алдагдал/ дээр үйл ажиллагааны бус орлогыг нэмж, үйл ажиллагааны бус зарлагыг хасч, ердийн ажиллагааны ашиг /алдагдал/-ийг тодорхойлно.

29.4. Ердийн ажиллагааны ашиг дээр онцгой шинжтэй орлогыг нэмж, онцгой шинжтэй зарлагыг хасч, татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/-ийг тодорхойлно.

29.5. Орлогын татварын хэмжээг тооцоолохдоо Монгол улсын татварын хуулийг мөрдлөгө болгоно.

29.6. Татвар төлөхийн өмнөх ашгаас орлогын татварт төлөхөөр тооцсон дүнг хасч, цэвэр ашиг /алдагдал/-ийг тодорхойлно.

30. Санхүүгийн тайланг Монгол улсын сангийн сайдын 1995 оны 40 дүгээр тушаалаар баталсан маягтаар сар, улирал бүр гаргах бөгөөд улирал, хагас жилийн болон жилийн тайланг холбогдох санхүү, татварын байгууллага болон Үнэт цаасны хороонд хүргүүлнэ.

## ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО

ҮНЭТ ЦААСНЫ ХӨДӨЛГӨӨНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ БҮРТГЭЛ

Үнэт цаасны нэр, төрөл: “А” компанийн энгийн хувьцаа

Нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Хүү болон бусад нөхцөл: 1995 оны ногдол ашиг нэгж хувьцаанд 25 төгрөг

| д/д | Огноо    | Гүйлгээний утга   | Гүйлгээ |                               |           |         |                          |           | Үлдэгдэл |                |           |
|-----|----------|---|---------|-------------------------------|-----------|---------|--------------------------|-----------|----------|----------------|-----------|
|     |          |   | Орлого  |                               |           | Зарлага |                          |           | тоо      | Нэг бүрийн үнэ | Үнийн дүн |
|     |          |   | тоо     | Нэг бүрийн худалдан авсан үнэ | Үнийн дүн | тоо     | Нэг бүрийн худалдсан үнэ | Үнийн дүн |          |                |           |
| 1.  | 96.01.01 | Эхний үлдэгдэл  |         |                               |           |         |                          |           | 800      | 200            | 160000    |
| 2.  | 96.01.04 | Арилжаагаар худалдаж авсан хэлцэл №016  | 300     | 220                           | 66000     |         |                          |           | 1100     |                |           |
| 3.  | 96.01.15 | Арилжаагаар худалдаж авсан хэлцэл №130  | 400     | 230                           | 92000     |         |                          |           | 1500     |                |           |
| 4.  | 96.01.20 | Арилжаагаар худалдсан хэлцэл №220   |         |                               |           | 600     | 250                      | 150000    | 900      |                |           |
| 5.  | 96.01.25 | Арилжаагаар худалдаж авсан хэлцэл №045  | 300     | 240                           | 72000     |         |                          |           | 1200     |                |           |
| 6.  | 96.01.20 | Арилжаагаар худалдсан хэлцэл №097   |         |                               |           | 800     | 250                      | 200000    | 400      |                |           |
| 7.  | 96.01.31 | Эцсийн үлдэгдэл Зах зээлийн өртгөөр /тухайн өдрийн хаалтын ханш/ Дундаж өртгөөр ДҮН |         |                               |           |         |                          |           | 400      |                |           |
|     |          |   | 1000    |                               | 230000    | 1400    |                          | 350000    | 400      | 260            | 104000    |
|     |          |   |         |                               |           |         |                          |           | 400      | 217            | 86800     |

БҮРТГЭЛ ХӨТӨЛСӨН  
НЯГТЛАН БОДОГЧ.....

ХЯНАЖ БАТАЛСАН .....

..... он.....сар.....өдөр

Маягт № А-11-1

ҮНЭТ ЦААСНЫ ХӨДӨЛГӨӨНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ БҮРТГЭЛ

Үнэт цаасны нэр, төрөл: .....

Нэрлэсэн үнэ: .....

Хүү болон бусад нөхцөл: .....

| д/д | Огноо | Гүйлгээний утга   | Гүйлгээ |                               |           |         |                          |           | Үлдэгдэл |                |           |   |
|-----|-------|---|---------|-------------------------------|-----------|---------|--------------------------|-----------|----------|----------------|-----------|---|
|     |       |   | Орлого  |                               |           | Зарлага |                          |           | тоо      | Нэг бүрийн үнэ | Үнийн дүн |   |
|     |       |   | тоо     | Нэг бүрийн худалдан авсан үнэ | Үнийн дүн | тоо     | Нэг бүрийн худалдсан үнэ | Үнийн дүн |          |                |           |   |
|     |       |   |         |                               |           |         |                          |           |          |                |           |   |
|     |       |   |         |                               |           |         |                          |           |          |                |           |   |
|     |       |   |         |                               |           |         |                          |           |          |                |           |   |
|     |       |   |         |                               |           |         |                          |           |          |                |           |   |
|     |       |   |         |                               |           |         |                          |           |          |                |           |   |
|     |       | Зах зээлийн өртөг<br>/Сүүлийн арилжааны<br>хаалтын ханшаар/<br>Дундаж өртгөөр | -       | -                             | -         | -       | -                        | -         | -        | -              | -         | - |
|     |       | ДҮН   |         |                               |           |         |                          |           |          |                |           |   |

БҮРТГЭЛ ХӨТӨЛСӨН  
НЯГТЛАН БОДОГЧ.....

ХЯНАЖ БАТАЛСАН .....

..... он.....сар.....өдөр

Маягт № А-11-2

ҮНЭТ ЦААСНЫ ҮЛДЭГДЭЛ БОЛОН БОРЛУУЛАЛТЫН  
ӨРТГИЙН ТООЦОО

| Огноо | Орлого |          |           | Зарлага |          |           | Үлдэгдэл |          |           |          | Дундаж өртөг |
|-------|--------|----------|-----------|---------|----------|-----------|----------|----------|-----------|----------|--------------|
|       | Тоо    | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо     | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо      | Нэгж үнэ | Үнийн дүн | Нийт үнэ |              |
|       |        |          |           |         |          |           |          |          |           |          |              |
|       |        |          |           |         |          |           |          |          |           |          |              |
|       |        |          |           |         |          |           |          |          |           |          |              |
|       |        |          |           |         |          |           |          |          |           |          |              |
|       |        |          |           |         |          |           |          |          |           |          |              |
|       |        |          |           |         |          |           |          |          |           |          |              |
|       |        |          |           |         |          |           |          |          |           |          |              |

1. Үнэт цаасны нийт тоо .....
2. Үнэт цаасны үнийн дүн .....
3. Үнэт цаасны дундаж үнэ /2:1/ .....

ТООЦООГ ҮЙЛДСЭН  
НЯГТЛАН БОДОГЧ.....

ХЯНАЖ БАТАЛСАН .....

..... он.....сар.....өдөр

“А” КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААНЫ БОРЛУУЛАЛТЫН  
ӨРТГИЙГ ТИЭЗ АРГААР ТООЦООЛБОЛ:

| Огноо | Орлого |          |           | Зарлага           |                   |                         | Үлдэгдэл                 |                          |                                  |          | Дундаж өртөг |
|-------|--------|----------|-----------|-------------------|-------------------|-------------------------|--------------------------|--------------------------|----------------------------------|----------|--------------|
|       | Тоо    | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо               | Нэгж үнэ          | Үнийн дүн               | Тоо                      | Нэгж үнэ                 | Үнийн дүн                        | Нийт үнэ |              |
| 1.1   |        |          |           |                   |                   |                         | 800                      | 200                      | 160000                           | 160000   |              |
| 1.4   | 300    | 220      | 66000     |                   |                   |                         | 800<br>300               | 200<br>220               | 160000<br>66000                  | 226000   |              |
| 1.15  | 400    | 230      | 92000     |                   |                   |                         | 800<br>300<br>400        | 200<br>220<br>230        | 160000<br>66000<br>92000         | 318000   |              |
| 1.20  |        |          |           | 600               | 200               | 120000                  | 200<br>300<br>400        | 200<br>220<br>230        | 40000<br>66000<br>92000          | 198000   |              |
| 1.25  | 300    | 240      | 72000     |                   |                   |                         | 200<br>300<br>400<br>300 | 200<br>220<br>230<br>240 | 40000<br>66000<br>92000<br>72000 | 270000   |              |
| 1.28  |        |          |           | 200<br>300<br>300 | 200<br>220<br>230 | 40000<br>66000<br>69000 | 100<br>300               | 230<br>240               | 23000<br>72000                   | 95000    |              |
| Дүн   | 1000   |          | 230000    | 1400              |                   | 295000                  | 400                      |                          | 95000                            | 95000    |              |

ТООЦООГ ҮЙЛДСЭН  
НЯГТЛАН БОДОГЧ.....

ХЯНАЖ БАТАЛСАН .....

..... он.....сар.....өдөр

“А” КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААНЫ ҮЛДЭГДЭЛ БОЛОН БОРЛУУЛАЛТЫН  
ӨРТГИЙГ СИЭЗ АРГААР ТООЦВОЛ:

| Огноо | Орлого |          |           | Зарлага           |                   |                         | Үлдэгдэл          |                   |                          |          | Дундаж өртөг |
|-------|--------|----------|-----------|-------------------|-------------------|-------------------------|-------------------|-------------------|--------------------------|----------|--------------|
|       | Тоо    | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо               | Нэгж үнэ          | Үнийн дүн               | Тоо               | Нэгж үнэ          | Үнийн дүн                | Нийт үнэ |              |
| 1.1   |        |          |           |                   |                   |                         | 800               | 200               | 160000                   | 160000   |              |
| 1.4   | 300    | 220      | 66000     |                   |                   |                         | 800<br>300        | 200<br>220        | 160000<br>66000          | 226000   |              |
| 1.15  | 400    | 230      | 92000     |                   |                   |                         | 800<br>300<br>400 | 200<br>220<br>230 | 160000<br>66000<br>92000 | 318000   |              |
| 1.20  |        |          |           | 400<br>200        | 230<br>220        | 92000<br>44000          | 800<br>100        | 200<br>220        | 160000<br>22000          | 182000   |              |
| 1.25  | 300    | 240      | 72000     |                   |                   |                         | 800<br>100<br>300 | 200<br>220<br>240 | 160000<br>22000<br>72000 | 254000   |              |
| 1.28  |        |          |           | 300<br>100<br>400 | 240<br>220<br>200 | 72000<br>22000<br>80000 | 400               | 200               | 80000                    | 80000    |              |
| Дүн   | 1000   |          | 230000    | 1400              |                   | 310000                  | 400               |                   | 80000                    | 80000    |              |

ТООЦООГ ҮЙЛДСЭН  
НЯГТЛАН БОДОГЧ.....

ХЯНАЖ БАТАЛСАН .....

..... он.....сар.....өдөр

ҮНЭТ ЦААСНЫ ҮЛДЭГДЭЛ БОЛОН БОРЛУУЛАЛТЫН ӨРТГИЙГ  
ЖИГНЭСЭН ДУНДАЖ ӨРТГИЙН АРГААР ТОДОРХОЙЛОЛ:

Тасралтгүй бүртгэх аргаар:

| Огноо | Орлого |          |           | Зарлага |          |           | Үлдэгдэл                  |                   |                          |          | Дундаж өртөг |
|-------|--------|----------|-----------|---------|----------|-----------|---------------------------|-------------------|--------------------------|----------|--------------|
|       | Тоо    | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо     | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо                       | Нэгж үнэ          | Үнийн дүн                | Нийт үнэ |              |
| 1.1   |        |          |           |         |          |           | 800                       | 200               | 160000                   | 160000   |              |
| 1.4   | 300    | 220      | 92000     |         |          |           | 800<br>300                | 200<br>220        | 160000<br>66000          | 226000   | 205          |
| 1.15  | 400    | 230      | 92000     |         |          |           | 800<br>300<br>400<br>1500 | 200<br>220<br>230 | 160000<br>66000<br>92000 | 318000   | 212          |
| 1.20  |        |          |           | 600     | 212      | 127200    | 900                       | 282               | 190800                   | 190800   |              |
| 1.25  | 300    | 240      | 72000     |         |          |           | 900<br>300<br>1200        | 212<br>240        | 190800<br>72000          | 262800   | 219          |
| 1.28  |        |          |           | 800     | 219      | 175200    | 400                       | 219               | 87600                    | 87600    |              |
| Дүн   | 1000   |          | 230000    | 1400    |          | 302400    | 400                       | 219               | 87600                    | 87600    |              |

ТООЦООГ ҮЙЛДСЭН  
НЯГТЛАН БОДОГЧ.....

ХЯНАЖ БАТАЛСАН .....

..... он.....сар.....өдөр

ҮНЭТ ЦААСНЫ ҮЛДЭГДЭЛ БОЛОН БОРЛУУЛАЛТЫН ӨРТГИЙГ  
ЖИГНЭСЭН ДУНДАЖ ӨРТГИЙН АРГААР ТОДОРХОЙЛОЛ:

Хугацаагаар үечлэн бүртгэх аргаар:

| Огноо    | Орлого |          |           | Зарлага |          |           | Үлдэгдэл |          |           |          | Дундаж өртөг |
|----------|--------|----------|-----------|---------|----------|-----------|----------|----------|-----------|----------|--------------|
|          | Тоо    | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо     | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо      | Нэгж үнэ | Үнийн дүн | Нийт үнэ |              |
| 96.01.01 |        |          |           |         |          |           | 800      | -        | -         | -        |              |
| 96.01.04 | 300    | 220      | 66000     |         |          |           | 1100     | -        | -         | -        |              |
| 96.01.15 | 400    | 230      | 92000     |         |          |           | 1500     | -        | -         | -        |              |
| 96.01.20 |        |          |           | 600     |          |           | 900      | -        | -         | -        |              |
| 96.01.25 | 300    | 240      | 72000     |         |          |           | 1200     | -        | -         | -        |              |
| 96.01.28 |        |          |           | 800     |          |           | 400      | -        | -         | -        |              |
| Дүн      | 1000   |          | 230000    | 1400    |          |           | 400      | 217      | 86800     | 86800    | 217          |

- 1. Үнэт цаасны нийт тоо  $800+1000=1800$
- 2. Үнэт цаасны нийт дүн  $160000+230000=390000$
- 3. Дундаж үнэ  $390000:1800=217$

ТООЦООГ ҮЙЛДСЭН  
НЯГТЛАН БОДОГЧ.....

ХЯНАЖ БАТАЛСАН .....

..... он.....сар.....өдөр